

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Төслийн товч тодорхойлолт.....	2
ОРШИЛ.....	3
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	6
3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	8
3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ	8
3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	8
3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	8
3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл..	8
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ТЭР БУМ МОД ХӨТӨЛБӨР.....	13
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14
11. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	19
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ	22

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол	2
Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим	3
Хүснэгт 3. Төслийн хугацаанд уурхайн нийт зарцуулах усны хэрэгцээний тооцоо	5
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	13
Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах ажил	13
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	15
Хүснэгт 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	19
Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	22
Хүснэгт 11. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	23


1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт

Хөөтийн нүүрс, шатах занарын ордын “Хөөтийн нүүрс” нэртэй ордын зүүн хойд жигүүрийн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос 300 км, төмөр замын Чойр өртөөнөөс баруун урагш 100 км, аймгийн төв Мандалговь хотоос зүүн хойш 130 км, Баянжаргалан сумын төвөөс баруун зүгт 26 км зайд, засаг захиргааны мужлалаар Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт Баянхошуу нэртэй газарт оршино.

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	107° 42' 20.53"	45° 41' 31.6"
2	107° 42' 20.53"	45° 41' 43.6"
3	107° 42' 41.53"	45° 41' 43.6"
4	107° 42' 41.53"	45° 41' 31.6"



Зураг 1. Төслийн талбайн байршлын тойм зураг

ОРШИЛ

“Хөөтийн нүүрс” нэртэй ордын зүүн хойд жигүүрийн нүүрсний ордыг захиалагч байгууллагын техникийн даалгаврын дагуу жилд 100.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтайгаар 4 жилд ашиглахаар төлөвлөсөн.

Ил уурхай жилд жилийн 4 улирал буюу 365 хоног ажиллана. Үүнээс баяр ёслол ба засвар үйлчилгээ, бэлтгэл ажил, төлөвлөгөөт сул зогсолт, цаг агаарын саатал зэрэг шалтгаанаар сул зогсох хоногуудыг хасаж нийт цэвэр 310 хоног ажиллахаар төлөвлөсөн. Захиалагч талын техникийн даалгавар болон уурхайн одоо ашиглаж буй тоног төхөөрөмжид тулгуурлан жилд ажиллах хоногийг сонгов.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Хуанлийн	хоног	365.0
2	Баяр ёслол	хоног	12.0
3	Амралт, засвар үйлчилгээ	хоног	15.0
4	Бэлтгэл ажлын хоног	хоног	7.0
5	Төлөвлөгөөт бус сул зогсолт	хоног	7.0
6	Цаг агаарын саатал	хоног	14.0
7	Уурхайн жилд цэвэр ажиллах хоног	хоног	310.0
8	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	24.0
9	Ээлжийн тоо	ш	2.0
10	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	цаг	12.0
11	Ээлжин дэх сул зогсолт (үдийн цай, тос түлш нэмэх), цаг	цаг	1.0
12	Ээлжийн бэлтгэл, төгсгөл, цаг	цаг	0.5
13	Өдрийн сул зогсолт	цаг	0.5
14	Бүтээлтэй ажиллах цаг	цаг	10.0
15	Цаг ашиглалт		0.80
16	Жилд ажиллах нийт цаг	цаг	3100

Уурхайн нээлт

Ил уурхайн гүн 30 м амсрын дундаж өргөн 170 м амсрын дундаж урт 520 м, ёроолын өргөн дунджаар 17 м, ёроолын урт 110 м байхаар тооцоо гарсан ил уурхай нь +1155 м-ийн төвшин хүртэл гүнзгийрнэ. Хөөт-1 хэсгийн нүүрсний орд нь нэг давхраасаас тогтоно. Энэ давхраасны уул геологийн тогтоц, уурхайн жилийн хүчин чадал, ашиглах техник тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт зэргийг үндэслэн гадаад болон дотоод траншейгаар нээхээр ТЭЗҮд тусгалаа. Нүүрсний давхраасны тогтоц болон хөрсний гадаад овоолгын байрлалыг харгалзан нээлтийн траншейг баруун хойноос зүүн урагш чиглэлд давхаргын суналын дагуу газрын гадаргууд ил гарсан гарш хэсгээс 113°-н азимутаар хайгуулын 0 ба I шугамын хооронд 1195.73 метрийн түвшнээс 80%-ийн налуутайгаар 5 м гүнд траншейн ёроолын өргөн 10 м, урт 60 м байхаар нэвтэрч нээнэ. Энд сонгож авсан шалтгаан нь уурхайн хөрс хуулалт, нүүрсний унал сунал, уулын ажил зэргийг харгалзан үзэв.

Уурхайн календарчилсан төлөвлөлт

2024 онд 81.92 мян.тн нүүрс олборлохоор тусгагдсан. Үүний дагуу 2024 онд 293.10 мян.м3 хөрс хуулахаар уулын ажлын төлөвлөгөөнд тусгалаа.

Овоолгын төлөвлөлт

Ашиглалтын нийт хугацаанд уурхайн хөрсийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлж, автосамосвалаар тээвэрлэн хөрсний гадаад овоолгод хураана. Уг процессын үр дүнд хөрс нь 20%-иар сийрэгжинэ. Хөрсний гадаад овоолгын байршлыг сонгон авахад гол анхаарах зүйл бол цаашид ашиглах нүүрсний давхаргуудыг хөрсний овоолгоор дарахгүй байхаар төлөвлөсөн. Уурхайн хэмжээнд ашиглалтын 4-н жилийн хугацаанд дотоод овоолго үүсгэх боломжгүй байна. Уурхай нь жигд доош гүнзгийрэх учир, дотоод овоолго үүсгэвэл нүүрсний нөөцийг дарахаар байна.

Уурхайн гадаад тээвэр

Хөөт-1 хэсгийн нүүрсний ордын уурхайн жилийн хүчин чадал 100 мян.тн бөгөөд өөрсдийн нүүрс угаан баяжуулах үйлдвэр рүү нийлүүлнэ. Уурхайн нүүрс угаан баяжуулах үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүнийг Чойр өртөө рүү 100 км-т тээвэрлэж борлуулна. Уурхайн гадаад тээвэрт жилд дунджаар 190.4 мян.тн баяжуулсан нүүрс тээвэрлэхээр байна. Уурхайн гадаад тээвэрт угаан баяжуулах үйлдвэр рүү тээвэрлэлтэд 60 тн даацтай LGMG MT-86 маркийн автосомасвал 2 ш, Чойр өртөө рүү тээвэрлэнэ.

Нүүрс угаах технологийн шийдэл

Нүүрс угаах үйлдвэр нь жилд 200.0 мян.тн нүүрс угаах хүчин чадалтай бөгөөд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн тоног төхөөрөмжтэй байхаар төлөвлөсөн. Төслийн хүрээнд нүүрс угаах үйлдвэр нь тасралтгүй ажиллагаатай байх ба Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаараас саатах, төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус засвар үйлчилгээний хоног болон техник, тоног төхөөрөмж ашиглалтын коэффициент зэргийг тооцож тусгасан бөгөөд төслийн нийт ажиллах хугацаа 6 жил байхаар төлөвлөсөн

Уурхайн ажилчдын хотхоны цэвэр усны хэрэглээ: Уурхайд нэг ээлжид байрлаж ажиллах ажилчдын тоо 110 байх ба нэг хүний хоногийн усны нормыг /50¹/ литр байхаар тооцов. Хөөтийн нүүрсний ордын зүүн хойд жигүүрийн нүүрсний ордыг ашиглах төслийн хүрээнд унд ахуйн зориулалтын усыг Иргэн Сосорбурам овогтой Цэвэлсүрэн /ЗИ50561101/-тэй хийсэн гэрээний дагуу зөөврөөр хангана.

¹ БОАЖЯ-ны А/301 тушаалаар ундны болон технологийн усны хэрэглээг тооцсон.

Хүснэгт 3. Төслийн хугацаанд уурхайн нийт зарцуулах усны хэрэгцээний тооцоо

№	Төслийн жил	Хотхоны усны хэрэглээ	Зам талбайн усалгаа	Ногоон байгууламж	Технологийн усны хэрэглээ		Нийт
					мян.м ³ /жил		
1	1-р жил	1.70	1.2	0.39	0.05	3.34	

Цахилгаан хангамж

Баяжуулах үйлдвэр болон уурхайд зориулж Баянжаргалан сумын төвөөс 10 кВ-ын өндөр хүчдэлийн цахи лгаан дамжуулах агаарын шугам татаж үйлдвэр болон уурхайг цахилгаан эрчим хүчээр хангана. Цахилгаан дамжуулах агаарын шугамын урт 3 км байна. Уурхайн ашиглалтын үед цахилгааны үндсэн 3 хэрэглэгч байна. Үүнд:

1. Засварын хэсэг
2. Ажилчдын хотхон, контор
3. Нүүрс угаах үйлдвэр

Түүнээс гадна ашиглалтын туршид шатахуун түгээх станц, тэсрэх материалын агуулах, автограж, халаалтын зуух зэрэг хэрэглэгчид цахилгаан эрчим хүч хэрэглэнэ.

Гадаал тээвэр

Хөөт-1 хэсгийн нүүрсний ордын уурхайн жилийн хүчин чадал 100 мян.тн бөгөөд өөрсдийн нүүрс угаан баяжуулах үйлдвэр рүү нийлүүлнэ. Уурхайн нүүрс угаан баяжуулах үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүнийг Чойр өртөө рүү 100 км-т тээвэрлэж борлуулна. Уурхайн гадаад тээвэрт жилд дунджаар 190.4 мян.тн баяжуулсан нүүрс тээвэрлэхээр байна. Уурхайн гадаад тээвэрт угаан баяжуулах үйлдвэр рүү тээвэрлэлтэд 60 тн даацтай LGMG MT-86 маркийн автосомасвал 2 ш, Чойр өртөө рүү тээвэрлэнэ.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ургамал зүй: Энэ газар нутаг нь ургамал газарзүйн мужлалын хувьд ЕвроАзийн хээрийн их мужид хамаарна. Элсэнцэр хөрстэй газар нь харганатай, харгана - агь - үетэнт хээртэй бөгөөд тэнд саман ерхөг, саман дурваа, агь, алтан шар шарилж, жижиг навчит ба одой харгана зонхилогч болно.

Ан амьтан: Манай орны төв хэсгийн хээрийн ургамалжилтай нутагт олон салаа гүн нүх малтан орогнож голдуу ногоон өвсөөр хооллогч мэрэгчид зонхилно. Зарим зүйлийн мэрэгчид хэт олширсон үедээ хөрс ургамалд сөрөг нөлөө үзүүлдэг. Нөгөө талаар газар малтагч жижиг мэрэгч амьтдын үйл ажиллагааны нөлөөгөөр хээрийн хөрс сийрэгжиж, ургамлын нөмрөг нь баяжиж нийтдээ бэлчээрийн ургац дээшилдэг ч явдал бий. Хээрийн бүсийн шувуудын бүрдэлд монгол болжмор нэлээд хувийг эзэлнэ. Шавжийн хувьд ядуувтар бүрэлдэхүүнтэй хээрийн шавжийн аймгийн төлөөлөгчид тархсан байна.

Ус зүй: Тус ордын талбайд урсгал ус, гол мөрөн байхгүй, гадагшаа урсгалгүй ай савд, тал-хээрийн болон говийн завсрын бүсэд оршино. Ордын талбайд гидрогеологийн тусгайлсан ажил хийгдээгүй юм. Усан хангамжийн хувьд байнгын урсгал ус байхгүй зөвхөн түр зуурын ус урсдаг, хуурай сайруудтай. Томоохон хотгор бүтцүүдийг дагасан давс, хужиртай, том жижиг нуур, тойром элбэгтэй. Гадаргуугийн ус ховор бөгөөд цөөн булаг шанд нь тухайн жилийн хур тунадаснаас хамаарч ундарга нь хэлбэлзэх ба гантай жил ширгэдэг. Ундны усны хэрэгцээг гол төлөв гар худгуудаас хангана.

Хөрсөн бүрхэвч: Дундговь аймгийн Баянжаргалан сум орчмын хөрс бүхэлдээ уулын хүрэн шороон хөрсний ангилалд хамаарна. Хүрэн хөрсний хэв шинж А-Вm-Вca(B)-ВСа(BC)-Cca(C) гэсэн үндсэн үе давхаргатай. Ялзмаг хуримтлалын (А) давхарга нь хар хүрэн, хүрэн, хүрэвтэр бор, сааралдуу бор хүрэн, цайвар хүрэн өнгөтэй, бөөмөрхөг бүтэц сул илэрсэн, гадаргаасаа эхлээд сайр чулуутай, доод хил зааг нь тод, зузаанаараа 5-10 см-ээс 20-25 см хүртэл янз бүр байна.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Хөөтийн нүүрс” нэртэй ордын зүүн хойд жигүүрийг ил аргаар ашиглах болон нүүрс угаан баяжуулах орчим нутаг нь заримдаг цөл ба цөлийн бүсийн цөлөрхөг хээрийн гөлтгөнөгүй бор, цөлөрхөг хээрийн мараалаг бор, нимгэн бор ба зарим газартаа цөлөрхөг хээрийн салхиар үүссэн хучмал үетэй бор хөрстэй.

Дэд бүтэц: Дундговь [Монгол Улсын аймаг](#) юм.1931 онд байгуулагдсан. 14 сум, 64 багтай. 68606 хүн амтай (2017 оны эцсээр) бөгөөд олон хүн ам огцом өсөж байна. Аймгийн төв Сайншанд нь улсын нийслэл Улаанбаатар хотоос 450км-т оршдог. Дундговь аймаг Монгол орны зүүн өмнөд хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залган оршдог. БНХАУ-тай 600 км-ээр хиллэдэг. Хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших MV-014715 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Хөөтийн нүүрс” ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр |

Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42.8 хувь, хүн амын 61 хувь нь оршин сууж байна. Тус аймагт 2017 оны эцсийн байдлаар 20844 өрхөд 68606 хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 1.5 хүн ногдож байна. Тэдний 61 хувь нь хот /аймгийн төв/ тосгонд, 15.2 хувь нь сумын төвд, 24.2 хувь нь хөдөөд оршин суудаг. Хүн амын 48.7 хувь нь эрэгтэйчүүд, 51.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Нэг өрхөд дунджаар 3.4 хүн ногдог. Нийт 19.7 мянган ажиллагсад байгаа нь ажил эрхэлж байгаа нэг хүнд 2.6 хүн ноогдож байна.

Хүн амын амьжиргааны түвшний үзүүлэлтээр тус аймаг улсын дунджаас дээгүүр байдаг. Нийт өрхийн 15.2 хувь, хүн амын 19.6 хувь нь амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой амьдарч байна.

3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1.Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ

2024 онд бэлтгэл ажил, уулын ажлын хөрс хуулалт, олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

3.2.Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

3.3.Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2024 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Ил уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэнэ. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

3.4.Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

Байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

- Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, тохируулгыг байнга хийж, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг хянаж байх.
- Утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009, Дизель хөдөлгүүртэй автомашин
- Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009 стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах
- Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу, шингэн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулан технологийн дагуу доторлосон халхавчтай, зориулалтын сав байрлуулж, ойр орчмыг дулааны улиралд ялаа, шавж үржихээс урьдчилан сэргийлж ариутгал хийж, хогийг хуримтлуулахгүйгээр зориулалтын цэгт хаях

- Дотоод шаталтын хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл, машин механизмуудаас ажлын үед гарах шатах тослох материалын агаар дахь ууршилт, засвар үйлчилгээг чанартай хийх, машин механизмын янданд шүүлтүүр тавих арга хэмжээг авах
- Шимт хөрсний овоолгын гадаргууг ургамалжуулах, хуурайшилт ихтэй үеүдэд овоолгыг услах зэрэг арга хэмжээ авах
- Гадаад болон дотоод зам талбайг засаж сайжруулах, услах
- Нийт талбай, үйлдвэр болон жижиг байгууламж баригдсан газарт, эсвэл тухайн барилга байгууламж барьсан талбайн хэмжээтэй тэнцэхүйц хэмжээний талбайд ургамал бүрхэвчийг нөхөн сэргээх, тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэх шаардлагатай.
- Бэлчээр тэжээлийн үнэт ургамлуудыг хамгаалах, тэдгээр ургамлыг тарих, нөхөн сэргээх ажлыг мэргэжлийн байгууллагаар өндөр түвшинд гүйцэтгүүлэх шаардлагатай. Хөөтийн нүүрсний ордын үйл ажиллагааны явцад тухайн орчны ургамал талхлагдах юмуу газрын хөрснөөс арчигдах аюултай байдаг тул нөлөөлөлд өртөхгүй газруудад хил хязгаар бий болгох, тэмдэгжүүлж, газрын доройтлоос сэргийлэх
- Төслийн үйл ажиллагааны явцад үүссэн газрын гадаргын эвдрэлд өртсөн хэсгүүдэд ажлын явцад төрх байдлын сайжруулалт хийж, ухмал нүх овоолгыг тэгшилж байх.
- Маршрутын бус замаар бүтээгдэхүүн тээвэрлэхгүй байх
- Суурингийн талбайд хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд болон тухайн орчиндоо сөрөг нөлөөллийг бий болгох газар ашиглалтыг төлөвлөхгүй байх.
- Төслийн явцад хийгдэх зайлшгүй шаардлагатай газар шорооны ажил, зам тавих, агуулах, үйлчилгээний хэсэг байгуулах зэрэг ажил нь барилга байгууламжийн дэвсгэрээс бусад талбайн газрын гадаргыг өөрчлөлтөнд оруулдаг ч орчны тохижилт, ногоон байгууламжийг зохистой байршуулж асуудлыг шийдвэрлэх боломжтой.
- Төслийн талбайн орчимд ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зайлуулахдаа зориулалтын хогийн цэг байгуулан асгаж байх шаардлагатай.
- Газрын хэвлийг төслийн хүрэнээс гадна аль болох бага хөндөх, ажил гүйцэтгэхэд ашиглах талбайг нөхөн сэргээх
- Ногоон байгууламж бий болгох.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. “ДҮНЬЛИ” ХХК-ийн “Хөөтийн нүүрс” ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний А/618 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу боловсруулав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд шатахуун хадгалах байгууламжийн талбай болон онгоцыг түлшээр цэнэглэхтэй холбоотой үйл ажиллагаанаас үүсэх гол ба болзошгүй сөрөг нөлөө, урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ, арга хэмжээний цар хүрээ, зардал, хэрэгжүүлэх давтамж, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн доорх хүснэгтэнд үзүүлсэн. БОМТ нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй. Энэхүү төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хураангуй бөгөөд жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай буюу байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулж байх шаардлагатай.

“Хөөтийн нүүрс” ордыг ашиглах явцад байгалийн болон бусад хүчин зүйлүүдийн нөлөөгөөр тухайн төслийн үйл ажиллагаа, төсөл хэрэгжиж буй орчинд ямар нэгэн байдлаар осол, эрсдэл үүсэж болзошгүй юм. Энэ нь төсөл хэрэгжүүлэгчийн хувьд санхүүгийн алдагдалд орохоос гадна олон хүн ажлын байргүй болох, орон нутгийн төсөвт төлөгдөж буй татвар зогсох, хамгийн гол нь хүний амь эрсдэх болон хөдөлмөрийн чадвараа алдах зэрэг хүчтэй сөрөг нөлөөллүүдийг агуулдаг байна. Төслийн үйл ажиллагаа, хүмүүсийн амьдралыг гэнэтийн осол, эрсдэлд хүргэдэг байгалийн гамшгууд болох усны үер, хүчтэй салхи, шуурга, газар хөдлөлт, ган, зуд, аянга цахилгаан гал түймэр зэрэг байгалийн гамшигт үзэгдлүүдийн ослын шинж чанар, эрч хүч өөр өөр байхаас гадна нөлөөллийн хор уршиг нь харилцан адилгүй байна.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших MV-014715 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Хөөтийн нүүрс” ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр |

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Цар хүрээ, хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар орчин								
Хийн хаягдлаар агаар бохирдох	Уурхайн үйл ажиллагаанд оролцож буй машин техник, хэрэгслүүдэд чанарын шаардлага хангасан түлш хэрэглүүлэх, машин техникийн засвар үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд тогтмол хийх	Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй талбай	-	-	-	Төсөл хэрэгжүүлж буй компани	Хуваарьт хугацаанд	БОННУ
Орчны тоосжилт үүсэх	Уурхайн талбайд хуурайшилт, тоосжилт ихтэй үед уурхайн гол зам, талбайг услах		-	-	-	2000.0	Дулааны улиралд тогтмол	Агаарын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль
Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл	Байгаль цаг уурын аюулт үзэгдэл болохоос өмнө цаг агаарын урьдчилсан мэдээг Дундговь аймгийн УЦУОШГазраас авч үйл ажиллагаандаа ашиглах		-	500.0	1	500.0	Жилийн туршид	БОННУ
Усны нөөц, чанар								
Орчны бохирдол үүсгэх	Хөөтийн нүүрс ордын уурхайн компанийн ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжийн ажиллагаанд хяналт тавих	Уурхайн талбай	-	-	-	Үйл ажиллагааны төсөвт багтсан	7 хоногт нэг удаа	БОННУ
Усны нөөцийн ашиглалт ихсэх	Компанийн ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдэн гарын усыг замын тоосжилт бууруулах болон ногоон байгууламжийн усалгааны зорилгоор дахин ашиглаж цэвэр усны нөөцийн хэмнэх	Усны нөөц	-	-	-		Зам услах үед	БОННУ
Ус ашиглалтын хяналтын дүн мэдээг жил бүр усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, ус ашиглах дүгнэлтийг жил бүр шинэчлэх		Уурхайн ус ашиглалттай холбоотой бүхий л	-	1000.0	1	1000.0	1-р улиралд	Усны тухай хууль

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших MV-014715 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Хөөтийн нүүрс” ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Ус ашигласны төлбөрийг төлөх		асуудлууд	-	-	-	-	1-р улиралд	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хууль
Ус бохирдуулсны төлбөр төлөх			-	-	-	-	1-р улиралд	
Хөрс, ургамлын бүрхэвч								
Газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	Хөөтийн нүүрс ордын уурхайн талбайд аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл олгох, шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, хуулсан шимт хөрсийг тухайн талбайг нөхөн сэргээхэд буцааж ашиглах, ашиглахгүй тохиолдолд шимт хөрсний овоолгод хадгалах	Газар хөндөлт хийх хэмжээгээр	-	-	-	Нөхөн сэргээлтийн зардал багтсан	Тайлант хугацаанд	БОННУ
Хөрсний чанар доройтох	Хөрсний шинжилгээний дүнгээр стандартаас давсан агууламж илэрвэл, давтан дээж авч баталгаажуулах ба дахин илэрвэл тухайн газрын хөрсийг хуулж гадаад овоолгын талбайд хаях	Уурхайн нийт талбай	га	-	-	Төлөвлөгөөний хяналт шинжилгээний хөтөлбөрт багтсан Тухай бүрт	Тухай бүрт	
Хөрсөнд бохирдол үүсэх	Хогийн сав, хогийн цэгийн орчинд ариутгал, халдваргүйтгэлийг хийх	Уурхайн нийт талбай	-	-	-	500.0	Тогтмол	
Амьтны аймаг								
Амьтдад сөргөөр нөлөөлөх	Уурхайн аливаа үйл ажиллагаанаас зэрлэг амьтан эрсдэх, гэмтэх зэргээс хамгаалах арга хэмжээг авах, хяналт хийх	Уурхайн талбай дахь зэрлэг амьтад	-	-	-	Үйл ажиллагааны төсөвт багтсан	Сард нэг удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Нийт зардал					4000.0			

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших MV-014715 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Хөөтийн нүүрс” ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр |

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Техникийн нөхөн сэргээлт

2024 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй.

Ордын олборлолт эхлэх үед шимт хөрсийн 0.2 м зузаантай хуулж, биологийн нөхөн сэргээлтэд ашиглах нөөц бий болох бөгөөд талбайн зүүн урд нөөц бодогдоогүй хэсэгт үүсгэн стандартын дагуу хадгална.

Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмж их нэгж	Тоо хэм жээ	Нэгжи йн зардал, л, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүл эх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
Биологийн нөхөн сэргээлт -	2024 онд биологийн нөхөн сэргээлийн ажил төлөвлөөгүй Шимт хөрс хадгалах хамгаалах ажил төлөвлөв.	м ³	0.5		2000000		
Нийт					2000000		

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ТЭР БУМ МОД ХӨТӨЛБӨР

“Дүнбли” ХХК нь 2024 онд орон нутгаас заасан чиглэлд дүйцүүлэн хамгаалах ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөв. Дундговь аймгийн Баянжаргалан сумын засаг даргаас авсан саналын дагуу Дүйцүүлэн хамгаалах болон тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд дараах ажлыг хийхээр төлөвлөөд байна.

Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах ажил

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээн ий цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжи йн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүл эх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	3-р багийн нутагт “Сүүл-Өндөр”-т 0.7 га талбайд нөхөн сэргээлт хих	0.7	-	-	-	5000000	2024 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
	3-р багийн нутагт байрлах 2 га талбайд			100ш		4000000	2024 онд	Тэр бум мод хөтөлбөр
	Нийт					9000000		

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших MV-014715 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Хөөтийн нүүрс” ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр |

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Дүнбли” ХХК-ны MV-014715 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Хөөтийн нүүрс” орд төслийн талбайн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй тул нүүлгэн суурьшуулах, нөхөн олговор олгох үйл ажиллагаа явагдахгүй

9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хөөтийн нүүрс” орд төслийн барилга байгууламжуудыг барьж байгуулах, тэдгээрийг ашиглахад Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт буй улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад шууд сөрөг нөлөөлөл байхгүй. Төслийн талбайд барилга байгууламжуудыг барьж байгуулах, төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.11-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Д/д	Хог хаягдлын төрөл	Хог хаягдлыг устгах	Хог хаягдлыг зайлуулах хугацаа	Нийт зардал /мян.төг/
1	Ахуйн хэрэглээний хог хаягдал	Үйл ажиллагаанаас гарах ахуйн хог хаягдлыг /хуванцар, шил, гялгар уут, төмөр бусад/ гэсэн 5 төрлөөр ангилан ялгаж дахивар хаягдал /шил, хуванцар, гялгар уут, төмөр/ зэргийг дахин боловсруулах эрх бүхий газарт шилжүүлэх	1-2 удаа	-
		Үйл ажиллагаанаас үүссэн дахин боловсруулах үйлдвэрт шилжих боломжгүй хаягдлыг сумын хог хаягдлын төвлөрсөн цэгт сумтай хог хаягдлын гэрээ байгуулан төлбөр хураамж төлж хүргэх	Сард	Сумын ИТХурлаар тогтоосон хог хаягдлын үйлчилгээний хураамжын тогтоолоор
		Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал бүрийг нэр төрлөөр бүртгэл хөтлөх	Сар бүр	-
		3 тасалгаат хогийн савыг байрлуулах /хотхон болон төслийн гадна талбай/	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө	1200
2	Аюултай хаягдал	Үйл ажиллагаанаас үүсэх аюултай хаягдал /аккумулятор, зай баттерей, принтрийн хор, тосол тосолгооны арчих тослох материал, техникийн хаягдал тос гэх мэт/-ыг тус бүр бүртгэл хөтлөх	Сар бүр	-
3	Аюултай хог хаягдал	Үйл ажиллагаанаас үүсэх аюултай хаягдал /аккумулятор, зай баттерей, принтрийн хор, тосол тосолгооны арчих тослох материал, техникийн хаягдал тос гэх мэт/-ийг дахин боловсруулах эрх бүхий үйлдвэртэй гэрээ байгуулан хуулийн хугацаанд шилжүүлэх	1-2 удаа	-
		Техникийн хаягдал тосыг солих явцад хөрсөнд нэвчихгүй арга хэмжээг авч, тусгай газрыг цементлэн талбай гаргах	-	-
		Эх үүсвэрээс гарах Хог хаягдлыг /аюултай болон энгийн/ байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр түр хадгалах цэгийг тогтоох	-	-
	Нийт			1200.0

11. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ

Аянга цахилгаан: Дулааны улиралд тохиолдох бөгөөд цаг агаарын мэдээг тогтмол мэдээлэх хэрэгтэй. Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, ил задгай цахилгааны утас зэрэг аянга үүсэж болзошгүй зүйлүүдийг хамгаалах

Газар хөдлөлт: Газар хөдлөлтийн мужлалаар төсөл хэрэгжих газар нь 6 баллын бүсэд хамаарна. Иймээс барилга байгууламж барихдаа зураг төслийн дагуу эрсдэлийг нарийвчлан авч үзэх шаардлагатай. Мөн ашиглалтын явцад газар хөдлөлтийн үед авах арга хэмжээг боловсруулах. Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бийболгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх.

Шороон шуурга: Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бийболгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх Халдварт өвчин: Уурхайн ажилчдад хууль бус ан агнахгүй байх түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөллийн талаар сургалт явуулах, хамгаалалтын хэрэгслээр хангах (амны хаалт г.м), аймгийн эрүүл мэндийн төвтэй харилцаа холбоотой байж мэдээлэл авч байх

Гал түймэр: Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслийн хангамж, цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах үд мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУ-н “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Аж ахуй нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”, “Гал түймрийн аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан тушаал, шийдвэрийн дагуу зохион явуулна

Авто тээврийн осол: Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчдын аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах. Уурхайн зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллах.

Хүснэгт 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Газар хөдлөлт		Зохих зураг төслийн стандартыг ашиглан гүйцэтгэгч байгууллагад шаардлага тавих, байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгөх	Төслийн талбай	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Төсөл эхлэхийн өмнө нэг удаа
Аянга цахилгаан		Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх	Төслийн талбай	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Төсөл эхлэхийн өмнө нэг удаа
Аадар бороо		Барилга байгууламжуудын зураг төсөл, чанарт цаг агаарын нөхцөлүүдийг тусгах, уурхайг үерээс хамгаалсан далан байгууламжтай болгох	Төслийн талбай	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Төсөл эхлэхийн өмнө, нэг удаа
Шороон шуурга	Агаарын чанарт хяналт шинжилгээ явуулах,	Уурхайд онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах	Төслийн талбай	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Төслийн хугацаанд байнга
Үер		Гадаргын усны урсцыг өөрчлөх, үерийн далан шуудуу татах, хүмүүст үерийн анхааруулга өгч хүний амь нас, дэд бүтцийг хамгаалах	Төслийн талбай	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Төслийн хугацаанд, аль болох хур борооны улирлаас өмнө
Байгалийн аюул, гамшгаас эрсдэл учрах	Гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Байгалийн аюул, гамшгаас эсрдлээс урьдчилан сэргийлэх	Уурхайн хэмжээнд	1500.0	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам, Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолын хавсралт
Халдварт өвчин	Үндэсний болон бүсийн халдварт өвчинтэй тэмцэх төлөвлөгөөтэй холбоо тогтоох	Өндөр эрсдэлтэй амьтадтай (шувууд) харьцахгүй байх хангалттай хэмжээний хамгаалалтын хэрэгсэлтэй байх (амны хаалт гэх мэт)	Төслийн талбай	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Төслийн хугацаанд, жил бүр

Нефт болон химийн аюултай бодис асгарах	Бохирдсон хөрсийг саармагжуулах, эрүүлжүүлэх талбайд зөөн хураах, асгаралтын эсрэг журмуудыг боловсруулж мөрдөх. ажилчидад асгаралтын талаар сургалтуудыг тогтмол өгөх.	Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.	Төсөл хэрэгжих бүс нутаг	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Төслийн хугацаанд байнга
Уурхайн хана, овоолгын нуралт		Доголын болон овоолгын нуурж болзошгүй хэсгүүдийг цаг тухайд нь унагаж байхын зэрэгцээ нурах болон гулсаж болзошгүй газруудад анхааруулах тэмдэг хадна. Уурхайн усыг байнга шүүрүүлэн хөрс, олборлолтын догол, мөргөцгийг усгүй хуурай байлгана. Уурхайг хур тунадасны ус үерээс хамгаалан, ус орж ирэх бүх талаар нь усны шуудууг татсан байх. Овоолгын талбайг байнга тэгшлэн, арчилж байхаас гадна овоолгыг цас бороо, үерийн уснаас хамгаалах ус орж ирэх боломжтой бүх талаас нь шуудуу байгуулах.	Төслийн талбай	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Төслийн хугацаанд
Хаягдлын болон эргэлтийн ус хадгалах далан хаалт сэтрэх		Мэргэшсэн геотехникийн инженер жил бүр далан, хаалтуудад үзлэг шалгалт хийх, далангийн усны түвшинд пьезометр ашиглаж байнга хяналт тавих, ус түвшин огцом багассан тохиолдолд шалтгааныг тогтоож, холбогдох арга хэмжээ авах шаардлагатай.	Төслийн талбай	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Төслийн хугацаанд жил бүр
Автомашинны осол		Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчдын аюулгүй ажиллагааны сургалтанд тогтмол хамруулах. Уурхайн зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллах. Байгалийн гамшигт үзэгдэл, үзэгдэх орчин хязгаарлагдах үед хэрэгжүүлэх онц байдлын журам боловсруулж мөрдөх	Төслийн талбай	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Төслийн хугацаанд
Нийт зардал				1500.0	

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Дүншли” ХХК-ийн “Хөөтийн нүүрс” ордын зүүн-хойд жигүүрийг ил аргаар ашиглах болон нүүрс угаан баяжуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээний локаль мониторингийн систем байгуулах нь зүйтэй. Мониторингийн цэгийг зөв сонгож, хугацаа, давтамж зэргийг нь оновчтой сонгож өгөх нь чухал юм. Тус төслийн орчимд явуулбал зохих экологийн хяналтын мониторингийн ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, мониторингийн ажлын давтамж, хэмжилт судалгааны ажлыг хариуцах мэргэжилтэн, мониторингийн үзүүлэлт зэргийг доорх хүснэгтэд тусган оруулж өгөв.


Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Усан орчин					
Усны рН, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл CO ₃ , хүчил HCO ₃ , кальци Ca, хлор Cl, кали K, магни Mg, сод Na, хүхэр S, хүнцэл As, бор B, бари Ba, кадми Cd, кобальт Co, хром Cr, зэс Cu, төмөр Fe, мөнгөн ус Hg, манган Mn, молибден Mo, никель Ni, хар тугалга Pb, селени Se, силиконSi, ванади V, цинк Zn, хөнгөн цагаан Al, мөнгө Ag, Хими бактерилогийн бүрэн шинжилгээ.	-Унд ахуйн хэрэглээнд ашиглах худагт	Жилд 2 удаа мониторингийн цэгүүдээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	Усны ерөнхий химийн шинжилгээ 20.0 мян.төг, Усны 23 элемент хүнд металлын шинжилгээ 60.0 мян.төг, Хими бактерилогийн бүрэн шинжилгээний үнэ 120.0 мян.төг 1 жилд 2 удаа буюу нийт 400.0 мян.төг	400.0 мян.төг	-MNS0900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ -Усны чанар хаягдал бохир ус MNS 4943:2000
Хөрсний төлөв байдал, бохирдолт					
Нефть, нефтийн бүтээгдэхүүн, Хар тугалга, Азот, Фосфор, Усан мандал, Кальци, Магни, Кали, Магни, Хлор, Сульфат, Карбонат, Гидрокарбонат, Ариун цэврийн тоо, Коли- титр, Перфрингес-титр	Төслийн талбайд	Жилд 2 удаа мониторингийн цэгүүдээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 40.0 мян.төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 60.0 мян.төг 1 жилд 100.0	100.0мян.төг *2* = 200.0 мян.төг	-MNS 5850:2008, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Агаарын чанар					
-Тоосжилт (PM ₁₀ , PSM, PM ₂₅) -Температур, Агаарын урсгал, Чийгшил, Нүүрстөрөгчийн исэл, Хүхэрт устөрөгч, Метан, Азотын	Төслийн талбайд	Жил бүр 2 удаа. Шаардлагатай тохиолдолд тухай бүрд нь.	24 цагийн хэмжилт хийж (O ₂ , SO ₂ , NO ₂ , CO , цаг агаарын үзүүлэлт)-ийн хамт	500.0 төг*2 = 1000.0 сая.төг	-ISO 9001:2000 MNS0017.2.5.12:88 Хүхэрлэг хий-SO ₂ шинжлэх ТХМ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших MV-014715 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Хөөтийн нүүрс” ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр |

давхар исэл, Аммиак г.м			тооцоход 500.0 мян.төг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2011 оны 10 сарын 10- ны өдрийн А-342 дугаар тушаалын хавсралтаар үнийг тооцов. 1 жилд 1000.0		буюу аэрозолины арга -MNS0017.2.5.11-88 Азотын давхар исэл
Ургамал					
-Хяналт шинжилгээ хийх талбайн хүрээ, хяналт үнэлгээгээр тодорхойлох үр дүнг тухай бүрд нь тодорхойлно.	Төслийн талбайд	жилд 1 удаа	Мэргэжлийн шинжээч хөлслөх, 1000.0 мян. төг	1000.0мян.төг	-Тухайн төслийн талбай болон орчных нь байгалийн унаган төрхөөрөө байгаа экосистемтэй харьцуулах аргаар тодорхойлох
Нийт дүн				2600.0 мян.төг	

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт хэрэгжих MV-014715 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Хөтгийн нүүрс” ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр |



Зураг 2. Төслийн мониторингийн цэгүүд

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй баг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид	Төслийн талаарх мэдээллийг цаасан болон presentation хэлбэрээр тайлагнах, хэлэлцэх	Төслийн нөөц, ашиглалтын техник технологи, ажилчид, бусад үйл ажиллагааны талаарх мэдээлэл, төслөөс байгаль орчин болон нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах багасгах чиглэлээр хийсэн арга хэмжээ, байгаль хамгаалах, дүйцүүлэн хамгаалах чиглэлээр хийсэн, нөхөн сэргээлтийн ажлын тухай	Жилд 1 удаа. 10-11 сард.	Төслийн үйл ажиллагаагаар уурхайн ойролцоох малчдын амьдрал ахуй, эрүүл мэнд, нийгэмд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөө, сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах чиглэлээр хэрэгжүүлбэл зохистой арга хэмжээ, төслийн үйл ажиллагааны талаарх санал бодлыг сонсох	Багийн эсвэл сумын төв

БОМТ-ний биелэлтийн тайланг тухайн оны 12 сарын 10-ний дотор БОАЖЯаманд ирүүлэх ба үүнээс өмнө хуваарийн дагуу орон нутгийн иргэд, засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчид, сонирхогч талуудад танилцуулж хэлэлцүүлэн тэдний санал бодлыг тайланд тусгасан байна.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших MV-014715 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Хөөгийн нүүрс” ордыг ил аргаар ашиглах төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр |

Хүснэгт 11. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	4000.0
2	Тэр бум мод ажлын зардал	4000.0
3	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ /Шимт хөрс хамгаалах/	2000.0
4	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	5000.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1200.0
6	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2600.0
8	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1500.0
9	2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	20300.0

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нөхөн сэргээх арга хэмжээнд нийт **20.3 сая** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Үүний 50 хувь 10.15 сая төгрөг байна. Бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг амгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.